

Техникийн тодорхойлолт

Санал болгох бараа нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна. Хуулийн 26.8-д зааснаар эсхүл түүнтэй дүйцэх” гэсэн тодотгол хэрэглэсэн техникийн тодорхойлолтод өөр бараа санал болгосон оролцогч техникийн тодорхойлолтод заасантай дүйцэх болохыг ТШЗ **Error! Reference source not found.**-т заасан баримт бичгээр нотолсон бол техникийн тодорхойлолтыг хангасан гэж үзнэ.

Барааны нэр: Иж бүрэн тавилгатай металл чимэглэлтэй, товгор сийлбэртэй карказан гэр

№	Захиалагчийн техникийн тодорхойлолт <i>(Тухайн барааны үзүүлэлт тус бүрийг дор жагсааж бичих ба хэрвээ чанарын баталгаат хугацаа шаардах бол бичнэ үү.)</i>	Санал болгож буй техникийн тодорхойлолт <i>(Зөвхөн санал болгож буй барааны техникийн тодорхойлолтыг бичнэ үү.)</i>	Тайлбар <i>(дээрх үзүүлэлтийг нотлох баримт бичиг болон танилцуулгыг хавсаргана)</i>
1	Стандарт: Гэрийн бүрэн мод Монгол гэрийн мод MNS0370-2021 стандартын техникийн тодорхойлолтыг хангасан зургаан ханатай гэрийн хэмжээ бүхий угсармал 1 иж бүрдэл мод байна. Баганагүй		
2	Хана: Ханын тур модыг уламжлалт ба орчин үеийн арга технологиор матаж толгойн хэсгийг бага зэрэг гадагшаа налууутайгаар (2 – 50), ханийн 4-5 см зузаантай 10 см-ын өргөнтэй банзаар ханыг хүрээлэн ф12мм ган боолтоор боохоор нүх гарган бэлтгэсэн байх. Ханын модыг хадгалагдсан 3мм-ээс доошгүй зузаантай тэмээний үдээр, зай завсар гаргахгүй чанга үдсэн байна. Хананы дээд хэсэг товгор металл хээтэй		
3	Гэрийн мод: Модны чийглэг нь MNS 2470: 78, гадаргуугийн барзгар нь MNS 2386:77, холболтын		

	бат бөх чанар нь MNS 2721:94, цавуун холболтын ус тэсвэрлэх чадвар нь MNS 2722:79, эд ангийн холболтын хэлбэр нь MNS 2447, будгийн хучилтын хатуулаг нь MNS 2398:89 стандартын шаардлага хангасан байна.		
4	Гэрийн дулаалгын иж бүрдэл: Сайн чанарын үйлдвэрийн болон гар аргаар бэлтгэсэн цагаан эсгий дээвэр 4 ширхэг, 6 ширхэг туургатай байх		
5	Гадна бүрээс: Улаан халзтай ус нэвтэрдэггүй цагаан бүрээс		
6	Унь: 5-7 см-с багагүй зузаан, 6 ханатай гэрийн стандарт урттай, гар аргаар сийлбэрлэсэн байна. Унины зэт 25 мм-ийн гүнтэй, огтлогдсон пирамид хэлбэртэй, тоононы мөөрний нүхэнд налуу байрлан, эргэж холхихгүй тохирсон байна. Унь тус бүр Монгол бэлэгдлийг элэрхийлсэн хас хээ болон товгор металл хээтэй.		
7	Эсгий дээвэр /дээврийн дулаалга/: 2 хос (4 ширхэг) Зургаан ханатай гэрийн дээвэр хонины ноосоор хийсэн эсгий материалтай байх бөгөөд эсгий дээвэр нь давхар буюу 2 хос нийт 4 ширхэг байна. Урд дээврийн урт нь 10.1 метр, хойд дээврийн 9.7 метр байна. Дээврийн дулаалгын бүрдүүлэх хэсгүүдийн зөрлөг нь хамгийн бага хэсэгтээ ойролцоогоор 20 см байна.		
8	Эсгий туурга /туурганы дулаалга/: 4-6 ширхэг 5-7 метрээс багагүй урттай 1.5		

	метр өндөртэй 4-5 хос хонины ноосоор хийсэн эсгий материалтай туурганы дулаалга байна. Туурганы дулаалгын бүрдүүлэх хэсгүүдийн зөрлөг нь хамгийн бага ~30 см-ээс багагүй байна.		
9	Гадна бүслүүр: 3 ширхэг Монгол дээсээр хийсэн байна.		
10	Тооно: Тооно 1 ширхэг 10-15 см-ийн зузаан, 1.5 метрээс багагүй голчтой, хээлж будсан байна. Тоононы цамхрааны 4 үзүүрт уях дааган чагтага, цамхрааны төвд уях гол чагтаганы гархийг бат бөх үзэмжтэй суулгаж бэхэлсэн байна Тоононы мөөрөнд унины үзүүр шурган орох огтлогдсон пирамид хэлбэртэй байна. Товгор металл хээтэй. Цэргийн дээд цол илэрхийсэн мөрдөсний сийлбэртэй.		
11	Дотор цаваг: Цагаан давуугаар хийсэн байна.		
12	Гэрийн даруулга /тэн/: 1 ширхэг 12 м олс		
13	Хаалга: 1 ширхэг 10 см-с багагүй зузаан 1.4 -1.5 метр өндөр, гар аргаар монгол уламжлалыг илэрхийсэн сийлбэртэй байна Хаалганы тотгонд ажлын зургийн дагуу 4-өөс 6 ширхэг хоногийг үүдэн хэсгийн унины голчийн 1/3 сууж байхаар ухаж хонхойлсон байна. хаалганы хоёр талын шанаанд бэхлэх 6 гархи, тотгоны голд байрлах чагтаганы нэг гархийг бат бөх тогтоож, хаалганы нугас бариулыг буцаж сугарахгүй хийцтэй эргээр үзэмжтэй суулгаж бэхэлсэн байна. Хаалганы		

	2 хавтасны дотор гадна талд металл тоногтой бариул, морины толгой тогтоосон байх		
14	Дотор бүслүүр: 1 ширхэг Монгол дээсээр хийсэн 19 м		
15	<p>Тавилга: 3 авдар, эргэнэг, 2 ор, эмээлний тавиур, ширээ, 4 ширхэг сандал, хувцасны шүүгээтэй байна.</p> <p>Авдар: 90*70 см хэмжээтэй 3мм сайн чанарын банзаар хийгдсэн 3 модон авдартай. Авдарын нүүрэн хэсгийн 4 талыг металл тоногоор тоноглож,</p> <ul style="list-style-type: none"> - 4 хүчтэн, - 5 хошуу мал, - металл товгор арслангаар тоноглосон. <p>Хувцасны шүүгээ: Нүүрэн тал 170 см өндөр ар тал 160 см өндөртэй 2 хаалгатай хувцасны шүүгээтэй хаалганы хавтасанд луу товойлгон сийлсэн байх.</p> <p>Ширээ, сандал: 80x120 хэмжээтэй майга хөлтэй ширээний тавцан нь Монгол уламжлалт хээн сийлбэртэй 4 ширхэг майга хөлтэй сандалтай.</p> <p>Эмээлийн тавиур: 2 тийшээ харсан морины толгойтой гол хэсэг нь хас хээн сийлбэртэй суурь сайтай хөлтэй байна.</p>		
...			

[Үнэлгээний хороо худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-д нийтэлсэн техникийн тодорхойлолтын жишиг нөхцөл, стандарт, загварыг баримтлан техникийн тодорхойлолтыг боловсруулна.]